



Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтэс

ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Арвайхээр хот
2019 он

Агуулга



АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....2



ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ.....3



АХУЙН НӨХЦӨЛ.....4



СУРАЛЦАХ НӨХЦӨЛ.....5



ЭРҮҮЛ АМЬДРАХ ОРЧИН.....6



АЮУЛГҮЙ БАЙДАЛ.....7-8



ХҮҮХЭД ГЭР БҮЛ.....9



АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Өвөрхангай аймаг нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 19 сум, 111 баг, 116.6 мянган хүн ам, 34.6 мянган өрхтэй. Нийт хүн амын 30.9 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 64.7 хувийг 15-64 насныхан, 4.4 хувийг 65-аас дээш насныхан эзэлж, 49.7 хувь нь эрэгтэй, 50.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт өрхийн 27.1 хувь нь аймгийн төвд, 24.7 хувь нь сумын төвд, 48.2 хувь нь хөдөөд суурьшсан.

Өдгөө зах зээлийн нөхцөлд хөдөө аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл, барилга, барилгын материал, аялал жуулчлалын салбаруудыг хөгжүүлж, орон нутгийн хөгжил дэвшилд хувийн хэвшлийн оролцоо дийлэнх хувийг эзэлж, бүтээн байгуулалт, бизнесийн цар хүрээ өдрөөс өдөрт өргөжин тэлж байна. Хосгүй сайхан байгаль өнө мөнх дурсагдах уламжлалт ёс заншлаа сэргээн хайрлан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, айл хотол, ахан дүүсээрээ ажлын байр бий болгож, амьдрал ахуйгаа дэвжээж, их бүтээн байгуулалтын ажилд Өвөрхангайчууд шамдан ажиллаж байна.

Өвөрхангай аймаг нь Монгол улсын төв хэсэгт Архангай, Булган, Баянхонгор, Төв, Дундговь, Өмнөговь аймгуудтай хиллэдэг. Газар зүйн байрлалаар далайн түвшнээс 1813 метрт өргөгдсөн, 102 градус 47 минутын уртраг 46 градус 16 минутын өргөрөгт, хойноос урагшаа 385 км, зүүнээс баруун хил хүртэл 310 км үргэлжилнэ.

Аймгийн нутаг дэвсгэрийг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзэхэд 2017 онд нийт нутгийн 90.5 хувийг хөдөө аж ахуйн газар, 5.8 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 2.4 хувийг ойн сан бүхий газар, 0.1 хувийг усан сан бүхий газар, 0.7 хувийг хот тосгон бусад суурин газар, 0.4 хувийг зам шугам сүлжээний газар эзэлж байна.



ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ


Аймгийн нийт өрх 34652 болж, өнгөрсөн оноос 1.5 хувь буюу 502 өрхөөр нэмэгдсэн байна. Нийт өрхийн 27.1 хувь нь аймгийн төвд, 24.7 хувь нь сумын төвд, 48.2 хувь нь хөдөөд суурьшсан байна. Нийт өрхийн 19.6 хувь нь нэг ам бүлтэй, 15.4 хувь нь 2 ам бүлтэй, 16.5 хувь нь 3 ам бүлтэй, 20.9 хувь нь 4 ам бүлтэй, 15.7 хувь нь 5 ам бүлтэй, 11.8 хувь нь 6 ба түүнээс дээш ам бүлтэй байна.

Сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд нэмэгдэж 2010 оноос орон сууцанд амьдардаг өрхийн тоо нэмэгдэж байгаа хэдий ч нийт өрхийн 79.0 хувь нь гэрт оршин сууж байна.

Байршил	Үүнээс					
	Бие даасан тохилог сууц	Бусад сууц	Гэр	Нийтийн байр	Орон сууцны байшин	Сууцны тусдаа байшин
ӨВӨРХАНГАЙ	82	208	27 381	142	1 408	5 431

Нийт өрхийн 79.0 хувь нь гэрт, 15.7 хувь нь сууцны тусдаа байшинд, 4.1 хувь нь орон сууцны байшинд, 0.6 хувь нь нийтийн зориулалттай бусад сууцанд, 0.2 хувь нь бие даасан тохилог сууцанд тус тус амьдарч байна.

Өрхийн тоо, сууцны төрлөөр





АХУЙН НӨХЦӨЛ

ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР	2017	2018
Төвлөрсөн систем	17601	18094
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	13816	14097
Бага оврын цахилгаан үүсгүүр	1833	1684
Дизель станц	48	45
Цахилгааны эх үүсвэргүй	722	732

УСАН ХАНГАМЖ	2017	2018
Бие даасан систем - халуун, хүйтэн устай	40	45
Бие даасан систем - хүйтэн	41	46
Зөөврийн	32564	33065
Төвлөрсөн усан хангамж - халуун, хүйтэн устай	864	971
Төвлөрсөн усан хангамж - хүйтэн устай	511	525

ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР	2017	2018
Ердийн галлагаа	32015	32505
Нам даралтын зуух	326	348
Төвлөрсөн систем	1551	1671
Цахилгаан халаагуур	128	128



СУРАЛЦАХ НӨХЦӨЛ

Ерөнхий боловсролын сургууль 2008-2009 оны хичээлийн жилээс 12 жилийн тогтолцоонд шилжиж, 6 настай хүүхдийг нэгдүгээр ангид элсүүлэх болсноор 5 хүртэлх насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж байна.

2018-2019 онд нийт 41 цэцэрлэгийн 259 бүлэгт 6898 хүүхэд хүмүүжиж байгаа нь өмнөх оныхоос 336 хүүхдээр буюу 5.1 хувиар өссөн байна.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдвал зохих (2-5 насны) хүүхдийн 87.3 хувь нь буюу 9759 хүүхэд хамрагдсан нь өмнөх оны хамрагдалтаас 7.5 хувиар өссөн байна.

2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 30 сургуулийн 795 бүлэгт 21508 хүүхэд өдрөөр суралцаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн тоо 1136 байгаагийн 35.2 хувь нь бага ангийн, 38.6 хувь нь дунд ангийн, 26.2 хувь нь ахлах ангийн багш байна.

Сумдын нэр	Ерөнхий боловсролын сургууль			Цэцэрлэг		
	ЕБС-н тоо	Бүлгийн тоо	Багш нарын тоо	Цэцэрлэгийн тоо	Бүлгийн тоо	Үндсэн багшийн тоо
БҮГД	30	795	1136	41	259	205
Баян-Өндөр	1	23	35	1	7	6
Бүрд	1	13	20	1	5	3
Бат-Өлзий	1	59	74	2	17	15
Баруунбаян-Улаан	1	21	30	1	7	4
Баянгол	1	20	30	1	7	6
Гучин-Ус	1	18	28	1	8	5
Есөнзүйл	1	19	26	1	6	3
Өлзийт	1	11	19	1	5	2
Зүүнбаян-Улаан	1	16	25	1	7	5
Богд	1	36	49	1	4	4
Нарийнтээл	2	25	33	2	10	7
Сант	1	24	35	1	9	3
Тарагт	2	16	20	1	4	4
Төгрөг	1	21	30	1	8	5
Уянга	3	76	105	2	17	8
Хайрхандулаан	1	18	26	1	4	3
Хужирт	1	46	59	2	18	14
Хархорин	3	91	139	5	29	27
Арвайхээр	6	242	353	15	87	81




ЭРҮҮЛ АМЬДРАХ ОРЧИН

2018 онд 2404 эх амаржиж 2403 хүүхэд төрсөн нь өмнөх оноос 25 хүүхдээр буюу 1.0 хувиар буурчээ. Эмнэлэгт 660 хүн нас барсны 5.4 хувийг 1 хүртлэх насны хүүхэд, 1.5 хувийг 1-5 хүртэл насны хүүхэд эзэлж байна.

Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 2018 онд 36 болж 2017 оныхоос 3 хүүхдээр буюу 7.7 хувиар буурч, 1-5 хүртлэх насандаа эндсэн хүүхэд 10 байгаа нь өмнөх оныхтой адилхан байна.

2018 онд халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 1013 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 101 хүнээр буюу 9.1 хувиар буурсан байна. Нийт өвчлөлийн 18.3 хувь нь салхин цэцэг, 18.3 хувийг тэмбүү, 20.6 хувийг цусан суулга, 8.6 хувийг трихоминиаз, 11.0 хувийг заг хүйтэн, 3.9 хувийг сүрьеэ, 0.6 хувийг вируст гепатит эзэлж байна.

Халдварт өвчлөлийг өмнөх оныхтой харьцуулбал салхин цэцэг 17.1 хувиар, трихоминиаз 1.1 хувиар, тэмбүү 3.7 хувиар, сүрьеэ 2.0 хувиар буурч, цусан суулга 8.5 хувиар вируст гепатит 0.2 хувиар, заг хүйтэн 3.5 хувиар өссөн байна.





АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Цагдаагийн газрын мэдээгээр 2018 онд аймгийн хэмжээнд 670 гэмт хэрэг гарсан нь өмнөх оныхоос 178 гэмт хэргээр буюу 36.2 хувиар өссөн байна. Энэ онд гарсан гэмт хэргийн 304 нь буюу 45.4 хувь нь аймгийн төвд үйлдэгджээ.

Нийт гэмт хэргийн дотор өндөр хувийн жин эзэлдэг хэргүүдийг авч үзвэл: Хулгайн хэрэг 2018 онд 258 гарсан нь нийт хэргийн 38.5 хувийг эзэлж, өмнөх оныхоос 46 хэргээр буюу 21.7 хувиар өссөн байна. Хулгайн хэрэг дотроо хувийн өмчийн хулгай энэ онд 173 гарсан нь өмнөх оныхоос 18.5 хувиар, авто тээврийн хэрэгслийн хулгай 23 хэргээр буюу 92.0 хувиар тус тус өссөн байна. Бусдын бие махбодид гэмтэл учруулсан хэрэг энэ онд 233 гарсан нь нийт хэргийн 34.8 хувийг эзэлж байна.

2018 онд гарсан гэмт хэргийг 492 хүн үйлдсэний 24 хүн буюу 4.9 хувь нь хүүхэд, 277 хүн буюу 56.3 хувь нь 18-34 насны залуучууд, 191 хүн буюу 38.8 хувь нь 35-аас дээш насныхан үйлджээ. Мөн нийгмийн байдлаар нь авч үзвэл: Хамгийн өндөр буюу 43.1 хувийг ажилгүй иргэд, 26.2 хувийг малчин иргэд, 17.3 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, 4.5 хувийг оюутан сурагч, 7.9 хувийг албан хаагч үйлдсэн байна. Нийт хэрэг үйлдэгчдийн 189 хүн буюу 38.4 хувь нь согтуудаа үйлдсэн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1182.8 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оныхоос 98.5 сая төгрөг буюу 9.1 хувиар өссөн байна. Нийт учирсан хохирлын 435.3 сая төгрөг буюу 36.8 хувийг нөхөн төлүүлжээ. Гэмт хэргийн улмаас 253 хүн гэмтэж, 35 хүн нас барсан нь өмнөх оныхоос гэмтсэн хүний тоо 31.1 хувиар, нас барсан хүний тоо 16.7 хувиар тус тус өсчээ.

Гэмт хэргийн төрөл	2017	2018	Харьцуулалт 2018/2017	
			тоо	хувиар
Үйлдэгдсэн бүх хэрэг	492	670	178	136.2
Бусдыг санаатай болон болгоомжгүй алах	8	4	-4	50.0
Бусдыг хүчиндэх	6	16	10	2.6 дахин
Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	7	4	-3	57.1
Танхайрах	4		-4	
ББМГУ гэмт хэрэг	139	233	94	167.6
Хулгай:	212	258	46	121.7
үүнээс: Малын	41	37	-4	90.2
Хувийн өмчийн	146	173	27	118.5
Авто тээврийн хэргслийн	25	48	23	192.0
ХАБЭ гэмт хэрэг	45	50	5	111.1
Албан тушаалын хэрэг				
Залилан мэхлэх	7	27	20	3.8 дахин
Байгаль хамгаалах журмын эсрэг	19	33	14	173.6
Бусад хэрэг	45	45	-	100.0

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧДИЙН ТОО

	2017	2018	Харьцуулалт 2018/2017	
			тоо	хувиар
Хэрэг үйлдэгчид бүгд	425	492	67	115.8
Үүнээс : Хүүхэд оролцсон	29	24	-5	82.8
18-34 насны	244	277	33	113.5
35-аас дээш	152	191	39	125.7
Нийгмийн байдлаар:				
Албан хаагч	19	39	20	205.3
Малчин	147	129	-18	87.8
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	37	85	48	229.7
Ажилгүй	173	212	39	122.5
Оюутан, сурагч	26	22	-4	84.6
Бусад	23	5	-18	21.7
Бүлэглэн үйлдсэн	116	110	-6	94.8
Согтуугаар	108	189	81	175.0
Албадан саатуулагдсан	1259	1499	240	119.1
Баривчлагдсан	635	981	346	154.5
Авто машин жолоодох эрх хасагдсан жолооч	731	921	190	126.0

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ

	2017	2018	Харьцуулалт 2018/2017	
			тоо	хувиар
Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	30	35	5	116.7
Гэмт явдлын улмаас гэмтсэн хүн	193	253	60	131.1
Нийт хохирол /сая.төг/	1084.3	1182.8	98.5	109.1
Үүнээс: Нөхөн төлүүлсэн	572.5	435.3	-137.2	76.0



ХҮҮХЭД ГЭР БҮЛ

Аймгийн хэмжээгээр 2018 онд өнчин хүүхдийн тоо 1622 болж, нийт хүүхдийн 4.5 хувийг эзэлж байна. Нийт өнчин хүүхдийн 6.3 хувь буюу 102 хүүхэд нь бүтэн өнчин, 93.7 хувь буюу 1520 нь хагас өнчин хүүхдүүд байна. Аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар өрх толгойлсон эмэгтэй 3504 байгаагийн 31.2 хувь нь аймгийн төвд, 68.8 хувь нь хөдөө сумдад амьдарч байна.

БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО

	2015		2016		2017		2018	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүтэн өнчин хүүхдийн тоо	129	67	108	54	105	53	102	47

ХАГАС ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО

	2015		2016		2017		2018	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Хагас өнчин хүүхдийн тоо	1693	859	1638	783	1668	813	1520	753

БҮРТГҮҮЛСЭН ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, ҮРЧЛЭЛТ

БҮГД	Гэрлэлт		Цуцлалт		Үрчлэлт	
	2017	2018	2017	2018	2017	2018
	536	561	52	78	75	58



Ашигласан материал, номзүй:

1. Аймгийн 2018 оны жилийн эцсийн нийгэм, эдийн засгийн танилцуулга
2. Хүн ам, өрхийн мэдээллийн сан
3. www.1212.mn
4. www.uvurkhangai.nso.mn

СТАТИСТИК - ХӨГЖИЛД ХӨТЛӨГЧ ХҮЧ

ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА О. ТҮМЭНЖАРГАЛ

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН Э.ӨҮЛЭН